

ГҮН-ГАЛУУТ ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ШУВУУДЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ

Ичинхорлоогийн Сарангэрэл^{1,3}, Гунгаагийн Амархүү^{1,2}, Очирбатын Адъяа¹, Төрмөнхийн Энхзаяа⁴; Сүхбаатарын Халиун⁵

¹ Сараана байгаль хамгаалах сан, 16-р хороо, 16-р хороолол, 9-31 тоот, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

² Шувуу хамгаалах төв, Лагшин төв, Амарын гудамж, Бага тойруу-1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

³ Олон улсын шувуулахуй, махчин шувуу хамгаалах холбоо, төв оффис-rue de Flandre 31, Брюссель 1000, Брюссель хот, Бельги улс

⁴ МУБИС-ийн Математик байгалийн ухааны сургуулийн 4-р түвшний оюутан, Бага тойруу-14, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

⁵ МУИС-Байгалийн шинжлэх ухааны сургуулийн 1-р түвшний оюутан, Их сургуулийн гудамж-1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс

харилцах хаяг: sarangerel.ich@gmail.com

ХУРААНГУЙ. Гүн-Галуут орон нутгийн хамгаалалттай газар нь хот суурин газартай хамгийн ойр орших биологийн нөөц арвинтай, нүүдлийн шувуудын олноор цуглардаг жижиг нуурууд, булаг шанд, баянбүрд, Хэрлэн голын шугуй бүхий ус намгархаг газартай, шувуу ажиглах, зураг авах сонирхолтой хүмүүсийн очих дуртай газруудын нэг юм. Харамсалтай нь сүүлийн жилүүдэд тус бүс нутгийн бэлчээрийн даац хэтэрч, булаг шандууд ширгэж, нуурын усны ургамал малд ихээр идэгдэж хүний болон байгалийн олон сөрөг нөлөөнд өртөж зэрлэг амьтан, ургамлын амьдрах орчин доройтож байгааг шувуу судлаач, ажиглагч нар өөрсдийн аяллын тэмдэглэлдээ нийтлэсэн. Бид ГГОНХГ-ын шувуудын зүйлийн бүрдэлийг танадах зорилгоор 1975-2021 оны хугацаанд боломжит дотоод, гадаадын боломжит бүх эх сурвалжуудыг шүүн нэгтгэхэд 19 багийн 43 овгийн 113 төрлийн 223 зүйлийг бүртгэлээ. Эдгээр зүйлүүдээс олон улсын байгаль хамгаалах улаан дансны ангилалаар олон улс, бүс нутагт ховордсон 30 зүйл бүртгэгдсэн байв. Нийт бүртгэгдсэн шувуудыг Гүн-Галуут орчим дах оршин амьдрах хэлбэрээр ангилан үзвэл өндөглөн зусдаг 37.2% (n=83), дайран өнгөрдөг 36.7% (n=82), тохиолдлын таардаг 9.4% (n=21), суурин 13% (n=29), зусдаг 3.1% (n=7), өвөл ирдэг 0.4% (n=1) тус тус эзэлж байв.

Түлхүүр үгс: Гүн-Галуут орон нутгийн хамгаалалттай газар нутаг, ус намгархаг газар, шувуудын зүйлийн бүрдэл, тогоруу, шувуу ажиглах аялал, экологийн боловсрол

ОРШИЛ

Манай улсын нийт нутаг дэвсгэрийн 21% улсын тусгай хамгаалалтад, 14 % орон нутгийн тусгай хамгаалалтад багтдаг (БОАЖЯ 2021). Тусгай Хамгаалалттай Газар Нутаг (ТХГН)-ийн тухай хуулинд Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авч, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоож хэрэгжүүлнэ гэж хуульчилсан бий. Мөн Байгаль Орчин Аялал Жуулчлалын (БОАЖ) сайдын тушаалаар батлагдсан журамд “Орон нутгийн хамгаалалттай газар” гэж тухайн орон нутгийн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг

хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилгоор орон нутгийн холбогдох нэгж хамгаалалтад авч болно гэж тус тус заасан байдаг (Мэндсайхан 2000).

Гүн-Галуут Орон Нутгийн Хамгаалалттай Газар (ГГОНХГ) нь Төв аймгийн Баяндэлгэр суманд харьяалагдаж, Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумд болон Багануур дүүргийн нутагтай хиллэн 19276,7 га талбай хамардаг (Сувд ба Шижирболд 2013). Тус газар нь нийслэл Улаанбаатар хотын Багануур дүүрэгтэй хамгийн ойр байрладаг ОНХГ бөгөөд нийслэлээс 130 км, Багануур дүүргээс 16 км, Багануурын нүүрсний уурхайгаас 5 км зайд оршдог. ГГОНХГ нь ойт хээр, хээрийн бүсийн зааг дээр оршдог, экосистемийн хувьд хад цохиот уулс, тал хээр, элсэрхэг газар болон баянбүрд, булаг шанд, гол, нуур зэрэг байгалийн төлөв байдлаараа өвөрмөц хэв шинжтэй тул олон зүйлийн ховор, нэн ховор амьтан, ургамлууд ихтэй.

Монгол оронд бүртгэгдсэн шувуудын 80% нь нүүдлийн шувууд бөгөөд Зүүн Ази-Австрали, Төв Ази, Зүүн Африк-Баруун Ази гэсэн дэлхийн 3 том нүүдлийн замаар дамжин нүүдэллэдэг онцлогтой. ГГОНХГ-ын жижиг нуурууд, баянбүрд, булаг шанд нь хот суурин газартай ойр байрладаг, шувуудад чухал ач холбогдолтой ус намгархаг газруудын нэг бөгөөд хавар, намрын улирал нүүдлийн шувууд олноор цугларан амрах, идээшлэх гол нутаг болдог тул олон улсын байгаль хамгаалах холбооны улаан дансны ангиллаар (IUCN Red List 2001) бүс нутаг, олон улсад ховордсон цагаан тогоруу, цэн тогоруу, хар тогоруу, реликт цахлай, борцгор хотон, хошуу галуу, идлэг шонхор, хонин тоодог зэрэг олон зүйлийн ховор шувууд бүртгэгдсэн байдаг. Иймд сүүлийн жилүүдэд тус бүс нутгийг зорин очих шувуу ажиглах сонирхолтой хүмүүсийн тоо нэмэгдсэнтэй холбоотой шувуудыг идэвхтэй бүртгэж, аяллын тэмдэглэлүүдийг олон улсын шувуу бүртгэлийн вэбсайт, аппликейшн, аяллын сэтгүүл, блогуудад (www.birdsmongolia.blogspot.com, www.birdmongolia.com, www.wildlifetourismongolia.com; <https://ebird.org/home>) идэвхтэй нийтлэх болсон. Энэ нь шувуу судлалын шинжлэх ухаан, орон нутгийн шувуу ажиглах тусгай сонирхлын аяллыг сурталчилан таниулахад чухал нөлөө үзүүлж, гадна, дотны аяллын компаниудын гол дайран өнгөрөх чухал газруудын нэг болсоор байна.

“Шувуу ажиглах” гэдэг нь байгалийн баялаг болох жигүүртэн амьтдын амьдралын онцлог, үйл хөдлөл зэргийг мэргэжлийн болон хувийн сонирхолдоо тулгуурлан ямар нэгэн сөрөг нөлөөгүйгээр таньж мэдэх, судлахыг хэлдэг бөгөөд сүүлийн үед олон хүмүүсийн “хобби” болон хөгжиж байна (Ганхуяг нар 2014). Өнөөдөр дэлхийн хэмжээнд шувуу ажиглах хоббинд ажил мэргэжил үл харгалзан бүхий л насны хүмүүс дурлаж, татагдах болсон. Иймд шувуу ажиглах эко-аялал, сургалтаар дамжуулан бага насны хүүхдийн байгаль хамгаалах сэтгэлгээг нэмэгдүүлэх, экологийн боловсрол олгох нь хамгийн үр дүнтэй бөгөөд байгаль хамгааллын хувьд чухал ач холбогдолтой. Мөн шувуу ажиглах сонирхолтой хүмүүсийн оролцоотой хот суурин газартай ойр байрлах шувууд их цуглардаг газруудад тогмол ажиглалт судалгаа явуулах нь шинжлэх ухаанд чухал хувь нэмэртэй юм. Иймд ГГОНХГ-ын биологийн нөөц, ус намгархаг газрыг түшиглэн байгаль хамгаалах, суурин судалгаа, сургалтын төв байгуулан бага насны хүүхдүүд, олон нийтэд шувуугаар дамжуулан байгалиа хайрлан хамгаалах, таньж мэдэх, экологийн боловсролыг нэмэгдүүлэх, шувуу ажиглах тусгай сонирхлын аялал жуулчлалыг зөв менежментээр хөгжүүлэх бүрэн боломжтой юм.

Харамсалтай нь сүүлийн жилүүдэд ГГОНХГ, ялангуяа ус намгархаг газарт байгаль орчны олон асуудлууд тулгарч нуур, булаг шандын ус ширгэж, зэгс шагшуургууд малд идэгдэж шувуудын амьдрах орчин доройтож буй талаар шувуу судлаач, ажиглагч нар аяллын тэмдэглэлдээ олон удаа дурдсан байдаг. Мөн ГГОНХГ-ын 2013 онд боловсруулсан менежментийн төлөвлөгөөнд тухайн бүс нутагт шувуудын үүрлэх орчин, булаг шанд, нууруудад хамгийн их сөрөг нөлөө, аюул занал учруулж буй хүчин зүйлээр малын бэлчээрлэлт, махчин амьтад, айлуудын нохой, уул уурхай, мөн нуурууд эх авч буй булаг шандууд болон цутгал голуудын ширгэлт, хуурайшилт зэрэг болохыг тодорхойлсон байдаг (Сувд ба Шижирболд 2013). Гэвч одоог хүртэл тус асуудлуудыг бууруулах, шийдвэрлэх байгаль хамгааллын арга хэмжээ, сургалт сурталчилгаа, судалгааны ажлууд дутмаг хэрэгжиж байгаа бөгөөд холбогдох байгаль орчны судалгааны мэдээ, баримт дутмаг байна.

Иймд ГГОНХГ-т түгээмэл тохиолдох шувуудын зүйлийн бүрдэл, нүүдлийн болон үржлийн шувуудын тоо толгой, амьдрах орчны судалгаануудыг мониторингоор гүйцэтгэж, цаашид олон жилийн динамик өөрчлөлтийг тодорхойлон хамгааллын ажлуудыг төлөвлөн, хэрэгжүүлж, байгалийн аялал жуулчлалыг биологийн олон янз байдлын судалгаа, хамгааллын ажлууд дээр тулгуурлан хөгжүүлэх шаардлагатай байна.

СУДАЛГААНЫ ТАЛБАЙ БА АРГА ЗҮЙ


ГГОНХГ нь зүүн талаараа Хэрлэн голтой хиллэдэг бөгөөд тус нутгийн Цэнгийн бүрд, Дэлбэрэхийн булаг, Их гүн Галуут нуур (Их Гүн нуур), Аяга нуур орчмын ус намгархаг газар нь зэгс шагшуурга, усны ургамал ихтэй тул нүүдлийн шувууд хавар, намрын улиралд олноор цугларч, зарим зүйл усны шувуудын гол амрах, идээшлэх, үржих таатай орчин болдог (Зураг 1). Харин Бага гүн нуур нь хамгаалалттай газар нутгийн хилийн гадна талд оршдог.

Их гүн Галуут нуур: ГГОНХГ-ын хамгийн том нуур бөгөөд булаг, гадаргын усаар сэлбэгддэг, д.т.д 1315 м, 1,25 км урт, 1,12 км өргөн, 1.3 км² талбайг хамрах шорвог нуур юм.

Аяга нуур: Жижиг нуурандаа тооцогддог бөгөөд д.т.д 1307 м, 0,6 км урт, 0,3 км өргөн, 0.18 км² талбайг хамардаг ба борооны ба гадаргын усаар сэлбэгддэг. Нуурын баруун хэсгээр ширгэж намагшин усны ургамал ургасан ба зүүн хойд хэсэг цэнгэг устай.

Цэнгийн бүрд: Хэрлэн голын хөндийд байрлах зэгс, шагшуурга, намаг, арал бүхий намгархаг газар бөгөөд голын шугуй, голын нугат хөндий, эрэг тохой, олон салаа садрага бүхий хэсэг нь олон зүйл шувуудын гол амьдрах орчин болдог.

Бид ГГОНХГ-ын шувуудын зүйлийн бүрдлийг гаргахдаа 1975-2021 оны хугацаанд шувуу судлаач, ажиглагч нарын шувуу ажиглалтын мэдээ, баримт, тайлан, эрдэм




Зураг 1. Гүн-Галуут орон нутгийн хамгаалалттай газар нутаг

шинжилгээний бүтээл, Монголын шувуу ажиглагчдын клубын цахим групп, блог хуудасны мэдээ, тэмдэглэл гэх мэт гадаад, дотоодын боломжит бүх эх сурвалжуудыг шүүж, нэгтгэн гаргалаа. Харин нийт бүртгэгдсэн шувуудын хамгийн их тоотой түгээмэл тохиолдож буй шувуудын зүйлийг танадах зорилгоор дээрх эх сурвалжуудын 2010-2021 оны хооронд нийт 11 жилийн 91 удаагийн шувуу ажиглалт, бүртгэлийн мэдээ баримт дээр тулгуурлан дүн шинжилгээ хийлээ. Мөн жил бүрийн малын тоо толгойн мэдээллийг үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг мэдээллийг ашиглав.


ҮР ДҮН

Зүйлийн бүрдэл болон хамгааллын статус: Гүн-Галуут орон нутгийн хамгаалалттай газарт нийт 19 багийн 43 овгийн 113 төрлийн 223 зүйл шувуу бүртгэгдсэн бөгөөд манай улсад бүртгэгдсэн нийт шувуудын зүйлийн 43% бүрдүүлж байна (Зураг 2). Эдгээрээс суурин шувууд 13.5% (n=30), нүүдлийн шувууд 86.5% (n=193)-ийг бүрдүүлж байв.



Зураг 2. Монгол улс болон ГГОНХГ-т бүртгэгдсэн шувуудын зүйлийн тоо

Үүнээс Нугасныхан, Хомноотынхон, Харцагынхан, Намнаахайнхан, Цахлайнхан, Хиазатынхан, Цэгцгийнхэн, Шонхорынхон, Хөмрөгийнхөн зэрэг овгийн шувуудын зүйлүүд түгээмэл тохиолдож байв (Зураг 3).



Зураг 3. Гүн-Галуут ОНХГ-т бүртгэгдсэн шувуудын зүйлийн тоо овог тус бүрээр

Нийт бүртгэгдсэн шувуудыг Гүн-Галуут орчим дах оршин амьдрах хэлбэрээр ангилан үзвэл өндөглөн зусдаг 37.2% (n=83), дайран өнгөрдөг 36.7% (n=82), тохиолдлын таардаг 9.4% (n=21), суурин 13% (n=29), зусдаг 3.1% (n=7), өвөл ирдэг 0.4% (n=1) тус тус эзэлж байв.

Харин олон улсын байгаль хамгаалах холбооны улаан дансны ангиллаар (IUCN red list, 2001) олон улсын болон бүс нутгийн улаан дансанд (BirdLife international 2017, Gombobaatar et all 2011) устаж байгаа, устаж болзошгүй, эмзэг, ховордож болзошгүй гэсэн зэрэглэлд нийт 30 зүйл багтсан байна. Үүнээс Монгол улсын улаан номонд 16 зүйл, зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховор зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) I, II –р хавсралтад 12 зүйл, зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийн (CMS) I, II-р хавсралтад 16 зүйл тус тус багтжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. ГГОНХГ-т бүртгэгдсэн ховор шувууд тэдгээрийн хамгааллын статус

№	Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Оршин амьдрах хэлбэр (ГГОНХГ)	Бүс нутгийн үнэлгээ*	Олон улсын үнэлгээ*	МУ-ын Улаан ном	CITES	CMS
1	<i>Anser cygnoides</i>	Хошуу галуу	ӨЗ	ХБ	Э	-	-	I, II
2	<i>Anser erythropus</i>	Одой галуу	Т	Э	Э	X	-	I, II
3	<i>Mareca falcata</i>	Гээзэгт нугас	ДӨ	ХБ	ХБ	X	-	-
4	<i>Sibirionetta formosa</i>	Байгалийн нугас	Т	Э	АӨ	X	II	I, II
5	<i>Aythya ferina</i>	Улаанхүзүүт шумбуур	ӨЗ	АӨ	Э	-	-	-
6	<i>Aythya baeri</i>	Ухаа шумбуур	Т	ҮБ	УБА	-	-	I, II
7	<i>Aythya nyroca</i>	Ундар нүдэн шумбуур	ДӨ	Э	ХБ	X	-	I, II
8	<i>Clangula heymanis</i>	Мөнгөлөг шунгаахай	Т	ҮБ	Э	-	-	-
9	<i>Ciconia boyciana</i>	Дорнын өрөвтас	Т	ҮБ	УБ	-	I	II
10	<i>Pelecanus crispus</i>	Борцгор хотон	Т	УБА	Э	HX	-	-
11	<i>Falco cherrug</i>	Идлэг шонхор	С	Э	УБ	-	II	-
12	<i>Haliaeetus leucoryphus</i>	Усны нөмрөг бүргэд	Т	УБ	УБ	HX	II	I, II
13	<i>Gypaetus barbatus</i>	Ооч ёл	Т	Э	ХБ	X	II	-
14	<i>Aegypius monachus</i>	Нөмрөг тас	С	АӨ	ХБ	-	II	-
15	<i>Aquila nipalensis</i>	Тарважи бүргэд	ӨЗ	АӨ	УБ	-	II	I, II
16	<i>Aquila haliaca</i>	Хан бүргэд	ДӨ	Э	Э	X	-	-
17	<i>Otis tarda</i>	Хонин тоодог	ДӨ	Э	Э	X	II	I, II
18	<i>Antigone (Grus) vipio</i>	Цэн тогоруу	ӨЗ	Э	Э	HX	I	I, II
19	<i>Grus monacha</i>	Хар тогоруу	Т	Э	Э	HX	I	I, II
20	<i>Leucogeranus leucogeranus</i>	Цагаан тогоруу	Т	УБА	УБА	HX	I	I, II
21	<i>Grus grus</i>	Хархираа тогоруу	ӨЗ	ХБ	АӨ	X	-	II
22	<i>Haematopus ostralegus</i>	Алаг хясаач	Т	ҮБ	ХБ	-	-	-
23	<i>Limnodromus semipalmatus</i>	Азийн цууцил	ӨЗ	Э	ХБ	X	-	-
24	<i>Limosa limosa</i>	Морин цууцал	ӨЗ	АӨ	ХБ	-	-	-
25	<i>Numenius madagascariensis</i>	Мадагаскар тутгалжин	ДӨ	АӨ	Э	-	-	I, II
26	<i>Numenius arquata</i>	Морин тутгалжин	ӨЗ	АӨ	ХБ	-	-	-
27	<i>Calidris ruficollis</i>	Шар түрүүт элсэг	ДӨ	АӨ	ХБ	-	-	-
28	<i>Calidris canutus</i>	Шармаг элсэг	ДӨ	АӨ	ХБ	-	-	-
29	<i>Larus (Ichthyaeetus) relictus</i>	Реликт цахлай	Т	УБ	Э	HX	I	I
30	<i>Emberiza aureola</i>	Шар элэгт хөмрөг	ӨЗ	ХБ	УБ	X	-	I, II

* Бүс нутаг болон олон улсын улаан дансны үнэлгээ: УБ-устаж болзошгүй, УБА-устаж байгаа, Э-эмзэг, ХБ-ховордож болзошгүй, АӨ-анхааралд өртөхөөргүй; **Оршин амьдрах хэлбэр:** ӨЗ-өндөглөн зусдаг, ДӨ- дайран өнгөрдөг, Т-тохиолдлын, С- суурин;

Эдгээр зүйлүүдээс манай оронд бүртгэгдсэн 6 зүйл тогорууны 3 зүйл (цэн тогоруу, хар тогоруу, цагаан тогоруу) олон улс болон бүс нутагт ховордсон, харин үлдсэн 2 зүйл (хархираа тогоруу, өвөгт тогоруу) тус бүс нутагт түгээмэл тохиолддог бөгөөд нийт 5 зүйл тогоруу Гүн-Галуут орчмын ус намгархаг газарт бүртгэгдсэн байна. Бидний нэгтгэсэн 11 жилийн (2010-2021) нийт 91 удаагийн ажиглалтын мэдээний 35-д 176 бодгаль цэн тогоруу, 2740 бодгаль өвөгт тогоруу тус тус бүртгэгдсэн байв. Харин 2010, 2013, 2014 онуудад шувуу ажиглалтын мэдээ байхгүйн улмаас цэн тогоруу Гүн-Галуут орчимд тохиолдсон эсэхийг мэдэх боломжгүй байсан бөгөөд бусад жилүүдэд жил бүр тодорхой тоогоор бүртгэгдсэн байв. Харин тогорууны төрлийн бусад зүйлүүдийн хувьд хархираа тогоруу 51 бодгаль, цагаан тогоруу 7 бодгаль, хар тогоруу 1 бодгаль тус тус зарим жилүүдэд бүртгэгдсэн байв. Үүнээс харахад Гүн-Галуут орчмын ус намгархаг газар нь тогорууны зүйлүүд ялангуяа цэн тогоруу, өвөгт тогоруу, хархираа тогорууны хувьд ихэнхи жилүүдэд тохиолдож байгаа нь тус бүс нутаг нь олон зүйл тогорууны хувьд чухал амьдрах болсоор буйг илтгэж байна.

ГГОНХГ-т хамгийн их тоотой бүртгэгдсэн шувууд: ГГОНХГ-т 2010-2021 оны хооронд нийт 223 зүйлийн 47643 бодгаль шувуу давхардсан тоогоор бүртгэгдсэн байв. Үүнээс хамгийн их тоотой бүртгэгдсэн шувууд буюу 250 бодгалиас дээш тоологдсон 34 зүйлийн 80%-ийг ус намгархаг газрын шувууд бүрдүүлж байв. Эдгээрээс улаанхүзүүт шумбуур, алаг шунгаач, өвөгт тогоруу, хондон ангир, ногоохон нугас, морин цууцал, умардын хавтгаалж, зэрлэг нугас зэрэг шувууд 1500-аас дээш тоотой бүртгэгджээ. Харин олон улсад ховордож (IUCN red list) буй шувуудаас хошуу галуу (n=980), морин цууцал (n=1995) улаанхүзүүт шумбуур (n=4772) зэрэг зүйлүүд их тоотой бүртгэгдсэн (Хүснэгт 2).

Хүснэгт 2. ГГОНХГ-т давхардсан тоогоор хамгийн их тоотой бүртгэгдсэн шувууд


№	Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Бүс нутгийн статус	Олон улсын статус	Оршин амьдрах хэлбэр (ГГОНХГ)	Бодгалийн тоо
1	<i>Aythya ferina</i>	Улаанхүзүүт шумбуур	АӨ	Э	ӨЗ	4772
2	<i>Bucephala clangula</i>	Алаг шунгаач	АӨ	АӨ	3	3236
3	<i>Grus virgo</i>	Өвөгт тогоруу	АӨ	АӨ	ӨЗ	2741
4	<i>Anas crecca</i>	Ногоохон нугас	АӨ	АӨ	ӨЗ	2400
5	<i>Tadorna ferruginea</i>	Хондон ангир	АӨ	АӨ	ӨЗ	2279
6	<i>Limosa limosa</i>	Морин цууцал	АӨ	ХБ	ӨЗ	1995
7	<i>Vanellus vanellus</i>	Умардын хавтгаалж	АӨ	АӨ	ӨЗ	1981
8	<i>Anas platyrhynchos</i>	Зэрлэг нугас	АӨ	АӨ	ӨЗ	1715
9	<i>Aythya fuligula</i>	Гээзгт шумбуур	АӨ	АӨ	ӨЗ	1431
10	<i>Larus mongolicus</i>	Монгол цахлай	АӨ	АӨ	ӨЗ	1371
11	<i>Fulica atra</i>	Халзан түнжүүр	АӨ	АӨ	ӨЗ	1338
12	<i>Mareca penelope</i>	Зээрд нугас	АӨ	АӨ	3	1263
13	<i>Anas acuta</i>	Шовтгоралаг нугас	АӨ	АӨ	ДӨ	1235
14	<i>Pluvialis fulva</i>	Азийн сүвээцагаан	АӨ	АӨ	ДӨ	1092
15	<i>Apus pacificus</i>	Хондлойцагаан ураацай	АӨ	АӨ	ӨЗ	1091
16	<i>Cygnus cygnus</i>	Гангар хун	АӨ	АӨ	ӨЗ	1063
17	<i>Anser cygnoides</i>	Хошуу галуу	ХБ	Э	ӨЗ	980

18	<i>Chlidonias leucopterus</i>	Буурал хараалай	АӨ	АӨ	ӨЗ	826
19	<i>Mareca strepera</i>	Бор нугас	АӨ	АӨ	ӨЗ	825
20	<i>Recurvirostra avosseta</i>	Алаг этэн	АӨ	АӨ	ӨЗ	701
21	<i>Tringa totanus</i>	Улаанхөлт хөгчүү	АӨ	АӨ	ӨЗ	520
22	<i>Tadorna tadorna</i>	Анхидал ангир	АӨ	АӨ	ӨЗ	513
23	<i>Pyrhacorax pyrrhacorax</i>	Улаанхошуут жунгаа	АӨ	АӨ	С	505
24	<i>Eremophila brandti</i>	Эвэрт болжмор	АӨ	АӨ	С	494
25	<i>Spatula clypeata</i>	Халбага нугас	АӨ	АӨ	ӨЗ	472
26	<i>Tringa erythropus</i>	Хар хөгчүү	АӨ	АӨ	ДӨ	469
27	<i>Corvus dauuricus</i>	Алагтуу хэрээ	АӨ	АӨ	ӨЗ	447
28	<i>Chroicocephalus ridibundus</i>	Хүрэнтолгойт цахлай	АӨ	АӨ	ДӨ	408
29	<i>Melanocorypha mongolica</i>	Монгол болжмор	АӨ	АӨ	С	373
30	<i>Apus apus</i>	Хурын урацай	АӨ	АӨ	ӨЗ	340
31	<i>Phalacrocorax carbo</i>	Тураг гогой	АӨ	АӨ	ДӨ	332
32	<i>Himantopus himantopus</i>	Эгэл хилэнжигүүр	АӨ	АӨ	ӨЗ	301
33	<i>Sterna hirundo</i>	Эгэл хараалай	АӨ	АӨ	ӨЗ	291
34	<i>Ardea cinerea</i>	Хөх дэглий	АӨ	АӨ	ӨЗ	268

* Бүс нутаг болон олон улсын улаан дансны үнэлгээ: Э-эмзэг, ХБ-ховордож болзошгүй, АӨ-анхааралд өртөхөөргүй; **Оршин амьдрах хэлбэр:** ӨЗ-өндөглөн зусдаг, ДӨ- дайран өнгөрдөг, Т-тохиолдлын, С- суурин, З-зусдаг;

Байгаль орчны тулгамдаж буй асуудлууд: ГГОНХГ-т байгаль орчны тулгамдаж буй асуудлуудын нэг бол малын тоо толгойн өсөлтөөс шалтгаалсан бэлчээрийн доройтол юм. Тус бүс нутгийн малын бэлчээр аргаль, тарвага, шувууд зэрэг зэрлэг амьтдын амьдрах орчинтой давхцаж, ус намгархаг газрыг түшиглэн зусдаг, үрждэг шувуудад сөрөг нөлөө учруулж буй талаар шувуу ажиглагч, судлаач нар аяллын тэмдэглэлдээ дурдсан байдаг. Мөн бэлчээрийн даац хэтэрснээс нуур, булаг шандны ус ширгэх, зэгс шагшуурга малд идэгдэх зэрэг олон асуудлууд тулгарч байгаагаас гадна уул уурхай багагүй нөлөөг үзүүлж байна.

Бид ГГОНХГ орших Баяндэлгэр сум болон хиллэж буй Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумд, Багануур дүүргийн 2010-2020 оны малын тоо толгойн мэдээг үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас авч үзэхэд малын тоо толгой жил бүр өсөх хандлагатай ажиглагдаж байв (Зураг 4). Иймд тухайн бүс нутагт бэлчээрийн менежмент хэрэгжүүлэн, зэрлэг амьтан, ургамлын амьдрах орчныг хамгаалах талаар орон нутгийн иргэдэд холбогдох сургалт, сурталчилгааны ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.



Зураг 4. ГГОНХГ –ын малын тоо толгой (хэмжих нэгж, мян.тол)

ДҮГНЭЛТ БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хот суурин газар өргөжин тэлэхийн зэрэгцээ хотын хүрээлэн буй орчин болон ус намгархаг газруудын экосистемд сөрөг нөлөөл учруулж байна. Ялангуяа хоттой ойр орших ус намгархаг газрууд байгалийн болон хүний хүчин зүйлийн нөлөөнд эмзэг өртөмтгий байдаг (Түвшинтөгс 2016) бөгөөд тэдгээр газруудыг нэн тэрүүнд хамгаалах, судлах ажлуудыг хийх нь хотын экосистемийн тогтвортой байдал болон биологийн олон янз байдлын хамгаалалд чухал ач холбогдолтой. Гэвч манай улсад хот суурин газартай ойр байрлах хамгаалалттай газар нутгууд болон ус намгархаг газруудад байгаль орчин, экологийн судалгаа, хамгааллын ажлууд дутмаг хэрэгжиж, ихэнхи газрууд хүн, мал, уур амьсгалын нөлөөлөлд өртөж зэрлэг амьтан, ургамлын амьдрах орчин доройтсоор байна.

ГГОНХГ нь хот суурин газартай хамгийн ойр байрлах биологийн нөөц арвин, шувуудад чухал ач холбогдолтой ус намгархаг газруудыг багтаасан орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг юм. Гэвч өмнөх жилүүдэд тус бүс нутагт байгаль орчин болон шувуудын мониторингийн судалгаа огт хийгдэж байгаагүй бөгөөд шувуу ажиглагч, сонирхогч, судлаачдын зарим жилүүдэд алаг цоог байдлаар бүртгэсэн шувуудын зүйлүүдийн мэдээллүүд үндэсний болон олон улсын аяллын вэбсайт, блогуудад хэвлэгдсэн байдаг хэдий ч энэ чиглэлийн шинжлэх ухааны өгүүлэл өмнө нь хэвлэгдээгүй байна. Харин өмнөх жилүүдэд хэвлэгдсэн тайлангуудад ГГОНХГ-т 15 багийн, 33 овгийн, 79 төрлийн 145 зүйл (Сувд ба Шижирболд 2013), шувуу судлаач, доктор Н. Цэвээнмядаг “Гүн галуут улсын тусгай хамгаалалттай газар нутаг байгуулахад шувуудын ач холбогдол” тайланд 15 баг 35 овог 84 төрлийн 158 шувуудын зүйлийн жагсаалтыг гарган, холбогдох зөвлөмжүүдийг гаргасан байдаг (Цэвээнмядаг 2013). Бид энэхүү өгүүлэлд 1975-2021 оны хугацаанд дотоод, гадаадын боломжит бүх эх сурвалжуудын мэдээллүүдийг шүүн, нэгтгэхэд шувуудын зүйлийн бүрдлийг 65 зүйлээр ахиулан нийт 19 баг 43 овог 113 төрлийн 223 шувуудын зүйлийг бүртгэлээ. Эдгээрээс суурин шувууд 13.5%, нүүдлийн шувууд 86.5%, үүнээс усны шувууд 53% -ийг бүрдүүлж байна. Мөн ГГОНХГ-т тэмдэглэгдсэн нийт шувууд Монгол орны нутаг дэвсгэрт бүртгэгдсэн нийт 519 зүйлийн шувуудын (Гомбобаатар 2022) 43%-ийг бүрдүүлж байна.

Иймд Гүн-Галуут орчимд бүртгэгдсэн шувуудын талаас илүү хувийг нүүдлийн усны шувууд бүрдүүлж байгаа нь тус нутгийн ус намгархаг газар нь усны шувуудын хувьд чухал амьдрах орчин болдогийг илтгэх боловч шувуудын мониторингийн судалгааг нуурууд, баянбүрд, Хэрлэн голын шугуй зэрэг ус намгархаг газрыг хамруулан судлах шаардлагатай.

Гүн-Галуутын ус намгархаг газарт цэн тогоруу, хархираа тогоруу, өвөгт тогоруу түгээмэл тохиолдож, хар тогоруу, цагаан тогоруу цөөн тоогоор ажиглагддаг бөгөөд манай оронд бүртгэгдсэн 6 зүйл тогорууны 5 зүйл бүртгэгджээ. Үүнээс цэн тогоруу, хар тогоруу бүс нутаг болон олон улсад (IUCN red list) эмзэг, цагаан тогоруу устаж байгаа ангилалд тус тус багтжээ. 2010-2021 оны хооронд бүртгэгдсэн үржлийн цэн тогорууны мэдээг авч үзэхэд судлаач Б. Бүүвэйбаатар, Мартин Гилберг нарын судалгаагаар (Buuveibaatar and Gilbert et al. 2016) үржлийн 1 хос (2010), шувуу ажиглагч Х.Түмэндэлгэр дэгдээхийтэй 1 хос (2015), ГГОНХГ-ын байгаль хамгаалагч н.Баярсайхан 2017 онд Цэнгийн бүрдэд 1 хос 1 дэгдийхий, шувуу судлаач, доктор Н. Цэвээнмядаг Цэнгийн бүрдэд 3 хос бүгд 2 дэгдээхийтэй, Аяга нууранд 1 хос 1 дэгдээхийтэй (2021) байхыг тус тус бүртгэсэн байв.

Харин цагаан тогорууны хувьд Монгол оронд нүүдлийн үедээ тохиолдлоор тааралддаг нэн ховор шувуу юм. Өмнөх баримтуудаас үзэхэд шувуу судлаач, доктор Н. Цэвээнмядаг, Б. Нямбаяр нарын Монгол оронд 1896-2012 оны хооронд бүртгэгдсэн цагаан тогорууны тоог харьцуулж үзсэн судалгааны өгүүлэлд 1994 оны 9-р сарын 3 нд Их гүн Галуут нууранд 2 хэсэг 34 бодгаль (5 болон 29) цагаан тогоруу манай оронд анх удаа, хамгийн их тоотой бүртгэгдсэн тухай баримтыг дурдсан байдаг (Цэвээнмядаг ба Нямбаяр, 2014). Мөн 2011, 2012, 2021 онуудад шувуу ажиглагч, судлаач нар нийт 6 бодгаль бүртгэсэн. Харин 2010 оноос өмнөх мэдээллээр шувуу судлаач, доктор Н. Цэвээнмядаг 2002 оны 5, 9-р саруудад Аяга нууранд 4 бодгаль, 2004 оны зун Их Гүн нууранд 4 бодгаль, 2006 оны 5-р сард 1 бодгаль, 2007 оны 10-р сард 2 бодгаль нийт 11 цагаан тогоруу тус тус бүртгэжээ.

Харин бусад ховор тэмдэглэгдсэн зүйлүүдээс дурдвал дэлхийн хэмжээнд ховордож буй Борцгор хотонг шувуу судлаач, доктор С. Гомбобаатар 2008 оны 7-р сард ГГОНХГ-ын хиллэдэг Хэрлэн гол дагуу ажиглан, зургийг авч баталгаажуулсан байдаг. Мөн хошуу галуу Гүн-Галуут орчмын ус намгархаг газарт жил бүр үржидэг байна. Үүнээс харахад ГГОНХГ-ын ус намгархаг газар нь олон улс, бүс нутагт ховордож буй шувууд, нэн ялангуяа тогорууны зүйлүүдийн нүүдлийн үедээ амрах, идээшлэх, үржих чухал амьдрах орчнуудын нэг болохыг илтгэж байгаа хэдий ч үржлийн үеийн болон амьдрах орчны судалгааг мониторингоор судалж, орон нутгийн хамгааллын зэрэглэлийг олон улс болон улсын хамгаалалттай газар нутагаар ахиулан, бүртгүүлж, холбогдох хамгааллын үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тус бүс нутагт нүүдлийн ховор шувууд олноор цуглардагтай (birding hot spot) холбоотой шувуу ажиглах сонирхолтой гадна, дотны хүмүүсийн очих дуртай газруудын нэг болсоор байгаа бөгөөд 2010 оны байдлаар 30 гаруй орны 2000 орчим жуулчид ирсэн байдаг. Сүүлийн жилүүдэд шувуу ажиглах сонирхолтой хүмүүсийн тоо нэмэгдсэнээр жилд ирэх хүмүүсийн тоо ч нэмэгдэх хандлагатай байна. Иймд шувуу ажиглах тусгай сонирхлын аялал жуулчлалыг шувуудын судалгаа, хамгаалал дээр тулгуурлан хөгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд мэргэжлийн байгууллагууд болон орон нутгийн удирдлагуудын хамтын ажиллагаа, оролцоо чухал ач холбогдолтой байна.

Харамсалтай нь сүүлийн жилүүдэд тус нутгийн Цэнгийн бүрд, Аяга нуур, Их гүн нуур, Дэлбэрэхийн булаг ширгэж, усны ургамал малд ихээр идэгдэж, ургамлан бүрхэвч багасаж буй талаар шувуу ажиглагч, судлаач нар аяллын тэмдэглэлдээ нийтлэн, анхааруулсан байдаг. Мөн тус бүс нутгийн малын тоо толгой сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, бэлчээрийн төлөв байдал жил ирэх бүрт доройтож, талхлагдаж байна. ГГОНХГ-ын байгаль орчны төлөвлөгөөний тайланд (2013-2018) бэлчээрийн доройтол, хуурайшилт, хулгайн ан, махчлал, уул уурхайн нөлөө их, бага хэмжээгээр нөлөө үзүүлж буй талаар үнэлэн, холбогдох хамгааллын үйл ажиллагаануудыг төлөвлөсөн хэдий ч судалгаа, хамгааллын ажлуудыг урьд жилүүдэд дутмаг хэрэгжүүлсэн байна.

Иймд ГГОНХГ-ын үнэт зүйл болсон ус намгархаг газар болон шувууд дээр тулгуурлан шувуудын судалгаа, хамгааллын ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлэх нь тухайн нутгийн экосистемийг бүхэлд нь хамгаалах чухал ач холбогдолтой. Мөн тус бүс нутагт суурин судалгаа, сургалтын төв байгуулан шувуу судлал, хамгааллын үйл ажиллагаагаар дамжуулан орон нутгийн иргэд, сургуулийн хүүхдүүдэд байгаль хамгаалах боловсрол олгох, тусгай сонирхолын аялал жуулчлалыг тогтвортой хамгааллын менежмент дээр

тулгуурлан хөгжүүлэх нь орон нутгийн нийгэм, эдийн засаг, байгаль хамгааллын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байна.

САНАЛ БА ЗӨВЛӨМЖ

- ГГОНХГ-т шувуудын судалгаа, идэш тэжээл, амьдрах орчин зэрэг байгаль орчин, биологийн олон янз байдлын цогц судалгаануудыг мониторингоор гүйцэтгэж, олон жилийн динамик өөрчлөлтийг хянаж, хамгааллын үйл ажиллагаануудыг тогтвортой хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Мөн ГГОНХГ-ыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд Байгалийн нөөц газар эсвэл Байгалийн цогцолборт газрын ангилалд хамруулан, хамгааллыг зэрэглэлийг ахиулан, хамгаалалтанд авах шаардлагатай байна.
- Орон нутгийн үнэт зүйлээр тодорхойлогдсон Цэн тогорууг экосистемийн шүхэр зүйлээр сонгон тухайн зүйлийн судалгаа, хамгаалал дээр тулгуурлан бусад зэрлэг амьтан, ургамлыг судлах, хамгаалах шаардлагатай.
- ГГОНХГ-ын өнгөрсөн жилүүдэд бүртгэгдсэн шувуу ажиглалтын мэдээнүүд тухайн бүс нутгийн шувуудыг зөвхөн бүртгэх төдийд явагдаж байжээ. Иймд тус бүс нутгийн ус намгархаг газрыг түшиглэн ирж буй шувууд дээр тулгуурлан шувуу судлах, хамгаалах суурин судалгааны төв байгуулж, судалгааг тогтмол явуулах, сургуулийн хүүхдүүд, орон нутгийн иргэдэд шувуу хамгаалал, экологийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, эко-аяллуудыг хэрэгжүүлэх нь тус бүс нутгийн цаашдын тогтвортой хамгаалалд чухал ач холбогдолтой.
- ГГОНХГ-т тулгамдаж буй асуудлыг тодорхойлох судалгаа явуулж, малын тоо толгойн хэт өсөлтийг багасгах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, хамгааллын ажлуудыг орон нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх шаардлагатай.
- Багануурын нүүрсний уурхайн байгаль орчны дүйцүүлэн хамгаалах ажлууд болон судалгааны ажлуудыг ГГОНХГ-ын биологийн олон янз байдлын судалгаа, хамгааллын ажлуудтай уялдуулан хамтран хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй.

ТАЛАРХАЛ

Энэхүү өгүүлэгийг бичихэд орон нутгаас боломжит мэдээллүүдээр хангасан Баяндэлгэр сумын засаг дарга З. Дэлгэрцэцэг, байгаль хамгаалагч Ч. Баярсайхан болон өгүүлэгтэй холбоотой санал, зөвлөмжийг өгч, холбогдох мэдээллүүдийг хуваалцсан шувуу судлаач, доктор Н. Цэвээнмядаг нарт талархсанаа илэрхийлье. Мөн Гүн-Галуутай орчимд жил бүр тогтмол шувуу ажиглаж, бүртгэлийн мэдээллүүдийг холбогдох эх сурвалжуудад нийтэлдэг бүх идэвхтэн шувуу ажиглагч, судлаач нарт талархлаа илэрхийлье!

АШИГЛАСАН БҮТЭЭЛ

1. Axel, B and Andreas, B. 2011. <http://birdsmongolia.blogspot.com/search?q=Gun+galuut>
2. Ayan travel. 2020. <https://www.birdmongolia.com/bird-blog/trip-report-two-day-bird-photography-trip-to-gun-galuut-nature-reserve-east-mongolia>
3. Birdlife International. 2001. The IUCN Red List Categories and Criteria.
4. BirdLife International. 2017. IUCN Red list for birds
5. Buuveibaatar, B., Martin Gilbert et al. 2016. Declining breeding population of white-naped cranes in Eastern Mongolia, ten-year update; Bird conservation international 26:490-504.
6. Gombobaatar, S. 2022. Birds of Mongolia: Field guide. Volume 2. Ulaanbaatar city.
Gombobaatar, S. and Monks, E.M. (compilers), Seidler, R., Sumiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J. E. M., Boldbaatar, Sh., Uuganbayar, Ch. (editors) (2011). Regional Red List Series Vol.7. Birds. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolian Ornithological Society. (In English and Mongolian) 1039 p.
7. The 'IUCN Red List Categories and Criteria' (IUCN, 2001)
8. Tseveenmyadag, N., B. Nyambayar. 2014. Is Siberian crane population recovering? A possible indirect evidence based on summer occurrences in Mongolia. Toodog ornithological journal, No 1: 1-7.
9. Байгаль орчин аялал жуулчлалын яам, 2021. Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын тайлан. Улаанбаатар хот.
10. Гантигмаа Ч., У. Айбек, П. Цогтсайхан, Х. Тэрбиш, С. Гомбобаатар, С. Шар, Б. Оюунцэцэг. 2013. Гүн-Галуутайн амьтан, ургамлын хөтөч. Гүн-Галуут НИХ, Степ форвард хөтөлбөр, Монгол улсын их сургууль. Улаанбаатар хот.
11. Ганхуяг, П., П. Амартүвшин, Х. Түмэндэлгэр. 2014. Монголд шувуу ажиглах аяллын өнөөгийн төлөв байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломж. Тоодог сэтгүүл 1:42-47. Улаанбаатар хот.
12. Мэндсайхан, С. 2000. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2000 оны 07-тоот тушаалын Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай журам. Улаанбаатар хот.
13. Нямбаяр Б., Цэвээнмядаг Н. 2009. “Монгол дахь Шувуудад чухал газруудын лавлах: Байгаль хамгаалалын түшиц нутгууд” (Important Bird Areas in Mongolia: Key sites for conservation) Редакторууд А.Болд, Ш.Болдбаатар, С.Дуламцэрэн, Х.Мөнхбаяр, Ч.Санчир, Б.Чимид-Очир. Улаанбаатар. 2009. х.105
14. Пүрэвсүрэн, Ц., Жаргалсайхан, Л. (2019). Монгол орны шувууд гэрэл зурагт лавлах. Улаанбаатар.
15. Сувд, П., Д. Шижирболд. 2013. Гүн-Галуутайн орон нутгийн хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө. Улаанбаатар хот.
16. Түвшинтөгс, С., Ганхуяг, П. 2016. Дарьгангын байгалийн цогцолборт газрын шувууд, тэдгээрийн хамгааллын байдал. Тоодог шувуу судлалын сэтгүүл 2:1-9. Улаанбаатар хот.
17. Цэвээнмядаг, Н. 2013. Гүн галуутай улсын тусгай хамгаалалттай газар нутаг байгуулахад шувууны ач холбогдол тайлан. Улаанбаатар хот.
18. Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://www.1212.mn/>
19. The Cornell Lab of Ornithology: <https://ebird.org/region/>